



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.09.01 № 1358
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН Н.ЖАВЗАНДУЛАМ
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Ням-Очирын Жавзандуламын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Ням-Очирын Жавзандуламын Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн

мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Ням-Очирын Жавзандуламын сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 хуудастай


ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Н.ЖАВЗАНДУЛАМЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгчөөр бие даан нэр дэвшиж сонгогдвол хэрэгжүүлэх 8 онцгой ажил:

1. Иргэний хяналтын үүргийг гүйцэтгэнэ.
 - Иргэдээ тогтмол мэдээлнэ.
 - НИТХ болон НЗДТГ, түүний харьяа агентлагууд дээр Иргэний зөрчигдсөн эрхийг хамгаалах чиглэлээр ажиллана.
 - Иргэний ниймгийн байгууллагуудтай хамтран ажиллана.
 - Дөрөв дэхь засаглалын үүрэг гүйцэтгэгч Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчидтэй хамтран ажиллана.
2. Иргэний санаачилгыг дэмжигч, уламжлагч байна.
 - Иргэдээс гарсан санал санаачилгыг НЗДТГ-т уламжилж, шийдэл гарц хайхад дэмжин ажиллана.
 - Иргэдэд бодлогын болон мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллана.
 - Иргэдийн санал санаачилгыг дэмждэг, хүлээн авдаг, сайн санаачилгыг урамшуулдаг тогтолцоог бий болгоно.
3. Хотын хөгжлийн сайн санаачилгыг дэмжин манлайлагч байна.
 - Хотын соёлыг дэлгэрүүлэгч, түгээгчийн үүргийг гүйцэтгэнэ.
 - Хотын соёл, хотын иргэний үүрэг, харилцааны талаар ТВ-ын контент бэлтгэх тал дээр хотын харьяа болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
 - Хотын соёлын журам боловсруулж, хэрэгжүүлэх талаа санаачилгатай ажиллана.
4. Хотын тулгамдсан асуудлыг шийдэгч байна.
 - Нийслэлийн агаарын бохирдол, хөрсний бохирдол болон үерийн усны шийдлийн хүрээнд хэрэгжиж буй төслүүдтэй танилцах, хяналт тавих, мэдээлэн ажиллана.
 - Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замуудын талаар форум хэлэлцүүлэг зохион байгуулна.
 - Иргэд, мэргэжлийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаас гаргасан санал санаачилгыг нийслэлд холбогдох шийдвэр гаргагчдад уламжил ажиллана.
5. Боловсролын элчийн үүрэг гүйцэтгэнэ.
 - Нийслэлийн боловсролын тэгш байдлын төлөө тууштай тэмцэнэ.
 - Боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллаж гарц шийдэл гарган ажиллана.
 - Сургалтын орчныг сайжруулах чиглэлээр төсөв, санхүүжилтыг нэмэгдүүлэхэд санаачилгатай ажиллана.
6. Эрүүл мэндийн салбарт холбогчийн үүрэг гүйцэтгэнэ.



- Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын байр, орчны тохижилтын асуудлаар төсөв, санхүүжилт шийдвэрлүүлэх талаар идэвхитэй ажиллана.
 - Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээг сайжруулах чиглэлд иргэд болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
 - Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлд мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
7. Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулагчийн үүрэгтэй ажиллана.
- Төр бол иргэддээ үйлчилгээ үзүүлэх байгууллага байх ёстой гэдэг үүднээс төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай болго талд мэдээллийн технологийн боломжийг ашиглан сайжруулах алхам хийнэ.
 - Төрийн үйл ажиллагааг цахимжуулах хэлбэрээр дата үүсгэх, түүнд тулгуурласан цахим шийдлүүдийг хийх замаар ухаалаг технологийг ашиглах, түүний санхүүжилтыг шийдвэрлүүлэх талд ажиллана.
 - Төрийн үйлчилгээний байгууллагуудын иргэдийг хүлээн авах танхимыг хүртээмжтэй, багтаамжтай, тухлаг, шуурхай болгох зохион байгуулалтыг үе шаттай хэрэгжүүлнэ.
8. Төрийг авлигаас ангид байлгах тал дээр ажиллана.
- Төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх чиглэлд бодит алхам хийнэ.
 - Төрийн эрх мэдлийг нэг хүнд хэв төвлөрүүлдэг тогтолцоог өөрчилж, зарим чиг үүргийг мэргэжлийн ТББ-уудаар гүйцэтгүүлдэг болгоход санаачилгатай ажиллана.
 - Төрийн зардлыг шилэн болгох ажлыг сайжруулна.
 - Төрийн зарим мэдээллийг цахим бөгөөд нээлттэй болгох ажлыг санаачилна.

